

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД  
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар  
2023 он**

## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- Иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;<sup>1</sup>
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;<sup>2</sup>
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;<sup>3</sup>
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.<sup>4</sup>

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал (1), хуулийн этгээдийн зардал (2), иргэнд үүсэх зардал (3) гэсэн гурван төрлөөр тооцдог.

Хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээдэд зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй, харин төрийн байгууллагад зарим тодорхой зардал үүсгэхээр тусгасан байх тул энэ хүрээнд үнэлгээг хийв. Түүнчлэн хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл биш тул дагаж мөрдөж буй 2016 оны Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд гарч байгаа зардлыг хамааруулахгүйгээр хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад нэмэлт зардал үүсгэж болох зохицуулалтыг сонгож зардлын тооцоог гаргасан болно.

### ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД БУЮУ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДАЛ

Төрийн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг болно. Энэ хэсэгт хуулийн төрийн байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад буюу

<sup>1</sup> Аргачлалын 2.3, 4.3 дахь заалт

<sup>2</sup> Аргачлалын 2.4.4, 4.4 дэх заалт

<sup>3</sup> Аргачлалын 4.4.3.1 дэх заалт

<sup>4</sup> Аргачлалын 2.1, 4.1 дэх заалт

улсын төсөвт хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцоолох зорилготой.

Төрийн байгууллагын зүгээс хуулийн төсөлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцсон ба дараах үе шаттайгаар гаргалаа.

1.Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;

2.Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох;

3.Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;

4.Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;

5.Хувилбарыг нягтлах.

Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хамтарсан багийн чиг үүргүүдийг тусгажээ. Эдгээр төрийн байгууллага, орон тооны бус нэгжийн чиг үүрэг нэмэгдсэн гэхээсээ илүүтэй одоогийн хэрэгжүүлж буй чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон.

Хуулийн төслийн 2.7 дугаар зүйлийн 1-д “Нийгмийн ажилтны мэргэжлээр дээд боловсролтой, нийгмийн ажлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, нийгмийн ажлын үйлчилгээ явуулах эрх авсан хүнийг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаар ажиллуулна.”, 6-д “Тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батална.”, 7-д “Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар батална.” гэж тусгасан байх тул хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулахтай холбоотой хүний нөөцийн болон захиргааны зардал гарахаар байна.

### **2.1. Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох:**

Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тодорхойлохдоо Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын орон тооны судалгаа, Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан нийгмийн ажилтны норматив, орон нутгийн байршил, засаг захиргааны нэгжийн тоог үндэслэв. Орон нутгийн

хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан /хүний нөөц/-ы хэрэгцээг нийт улсын хэмжээгээр газар нутгийн байршил, засаг захиргааны нэгжээр тооцов.

Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны гүйцэтгэх чиг үүрэг нь өдөр бүр, сар, жилээр байнга давтагдан хийгдэх тасралтгүй үйл ажиллагаа учраас чиг үүрэг тус бүрээр хөдөлмөр зарцуулалтыг тооцох боломжгүй бөгөөд ийнхүү тооцох шаардлагагүй гэж үзэж, хүний нөөцийн хэрэгцээг бүтцээр нэмэгдэх орон тоогоор тодорхойлов.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас авсан судалгаагаар сум, хороонд 699 нийгмийн ажилтан ажиллаж байна.

Харин Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолоор баталсан нийгмийн үйлчилгээний жишиг нормативын дагуу сум, хорооны түвшинд ажиллах нийгмийн ажилтныг тооцоход улсын хэмжээнд нийт 1044 нийгмийн ажилтан ажиллах шаардлагатай байна.

Баримталсан норматив: Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан нийгмийн ажилтны норматив

Сумын хүн амын тоо	Нийгмийн ажилтны тоо	Хорооны хүн амын тоо	Нийгмийн ажилтны тоо
1000-3000	1	4000-5000	1.0
3000-аас дээш	1+нэмэгдэж байгаа 3000 хүн ам тутамд 1 нийгмийн ажилтан	5000-аас дээш	1+нэмэгдэж байгаа 5000 хүн ам тутамд 1 нийгмийн ажилтан

Хуулийн төслөөр сум, хороонд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан 1 хүн байхаар тооцож үзэхэд суманд 330, хороонд 204 нийт 534 хүний нөөцийг бүрдүүлэх шаардлагатай гэсэн тооцоо гарч байна.

Хүний нөөцийн нийт хэрэгцээ = 534 хүн

## **2.2. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох**

Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн 3 зардлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлно. Өмнөх үе шатанд гаргасан ажиллах шаардлагатай хүний нөөцөд зардлын бусад бүрдлүүдээс оногдох хэсгүүдийн нийлбэрээр уг зардал тооцогдоно.

Аргачлалд албан ёсны эх сурвалжаас авсан тоо баримтыг эх сурвалж болгохоор заасан тул нэг албан хаагчид ногдох хүний нөөцийн хувьсах зардал болон материаллаг зардлын талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн

байгууллага, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас тодруулж, төсөв төлөвлөхөд ашигладаг норм, нормативыг харгалзан үзсэн болно.

Хүний нөөцийн зардлыг тооцох нормативын тухайд төрийн албан хаагчийн тохирох ангилал зэрэглэл, цалингийн сүлжээг баримтлав. Сум, хороонд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны 534 орон тоог шинээр бий болгохоор төлөвлөлөө. Энд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны орон тоог тооцохдоо одоо байгаа сум, хороо, багийн нийгмийн ажилтны орон тооноос 201 (735-534) бага буюу аймгийн төвийн баг дээр нийгмийн ажилтны орон тоог цаашдаа үе шаттай нэмэгдүүлэх тооцоолол хийсэн.

Төсвийн тооцоололд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын ТҮБД-4 шатлал дээр нэмж 2024 онд төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэх тооцооллоор 1,470,700 төгрөгөөр, мөн холбогдох нэмэгдлүүдийг цалингийн сангийн 15%-аар, хоол, унааны хөнгөлөлтийг орон нутагт 1 өдөр 10,000 төгрөг, нийслэлд 15,000 төгрөг байхаар тооцооллыг хийсэн. Цалин, байгууллага төлөх НДШ-д 14.0 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 0.8 тэрбум төгрөг, тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн зардалд 1.6 тэрбум төгрөг нийт 16.4 тэрбум төгрөг шаардлагатай гэж тооцооллоо.

**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ НЭГ АЛБАН ХААГЧИЙН  
ЦАЛИНГИЙН ЖИЛИЙН ЗАРДАЛ**

(төгрөгөөр)

№	Зардлын ангилал	орон тоо	1 хүн	Жилд /төгрөг/
1	Үндсэн цалин /хороо/	204	1,470,700	3,600,273,600.0
	Үндсэн цалин /сум/	330	1,470,700	5,823,972,000.0
2	Нэмэгдэл /хороо/	204	514,745	540,041,040.0
	Нэмэгдэл /сум/	330	514,745	873,595,800.0
3	Хоол, унаа	204	15,000	740,520,000.0
4		330	10,000	798,600,000.0
<b>Цалингийн сан</b>				<b>12,377,002,440.0</b>
5	НДШ /12.5%/			1,670,895,329.4
<b>Нийт дүн</b>				<b>14,047,897,769.4</b>

Хүний нөөцийн нийт зардал = 14,047,897,769.4 (14.0 тэрбум) төгрөг

## 2.3.Бусад зардал буюу материаллаг зардал:

### Материаллаг зардал:

Төрийн албан хаагчийн материаллаг зардлыг тооцоход Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-ийг баримталж тооцсон.

Дөрөв.Дэс түшмэл /түүнтэй адилтгах албан тушаалтан/-ийн жишгийг баримтлав.

### **Нэг албан хаагчид ногдох тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зардлын тооцоо**

*(Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт)*

№	Тавилга хэрэгслийн төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Бичгийн ширээ	1	348,910.0	348,910.0
2	Бичгийн ширээний сандал	1	250,600.0	250,600.0
3	Компьютер /иж бүрэн/	1	1,740,640.0	1,740,640.0
4	Телефон утас	1	14,120.0	14,120.0
5	Компьютерын ширээ	1	184,300.0	184,300.0
6	Бичиг хэрэг хадгалах шүүгээ	1	417,700.0	417,700.0
<b>Нийт дүн</b>				<b>2,956,270.0</b>

Нийт 534 албан хаагчдад тавилга, эд хогшил худалдан авах зардлын тооцоо:

№	Албан хаагчийн тоо	1 албан хаагчид тавилга, эд хогшил худалдан авах зардал	Нийт дүн /төгрөгөөр/
1	534	2,956,270	1,578,648,180.0

Материаллаг зардлын дүн = 1,578,648,180.0 (1.5 тэрбум) төгрөг

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23, 27 хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баримталж үйл ажиллагааны зардлыг тооцлоо.

/төгрөгөөр/

№	Аймаг	2021* оны өрхийн тоо	Сургалт зохион байгуулах зардал	Олон нийтэд чиглэсэн	Нийт
1	Архангай	28285	375	525	25,456,500.0
2	Баян-Өлгий	25630	375	525	23,067,000.0
3	Баянхонгор	26625	375	525	23,962,500.0
4	Булган	19069	375	525	17,162,100.0
5	Говь-Алтай	16521	375	525	14,868,900.0
6	Дорноговь	21115	375	525	19,003,500.0
7	Дорнод	24720	375	525	22,248,000.0
8	Дундговь	14847	375	525	13,362,300.0
9	Завхан	21616	375	525	19,454,400.0
10	Өвөрхангай	34424	375	525	30,981,600.0
11	Өмнөговь	23164	375	525	20,847,600.0
12	Сүхбаатар	18817	375	525	16,935,300.0
13	Сэлэнгэ	29947	375	525	26,952,300.0
14	Төв	28574	375	525	25,716,600.0
15	Увс	22315	375	525	20,083,500.0
16	Ховд	23329	375	525	20,996,100.0
17	Хөвсгөл	39652	375	525	35,686,800.0
18	Хэнтий	25141	375	525	22,626,900.0
19	Дархан-Уул	29512	375	525	26,560,800.0
20	Орхон	29074	375	525	26,166,600.0
21	Говьсүмбэр	5261	375	525	4,734,900.0
22	Улаанбаатар	412527	375	525	371,274,300.0
<b>Улсын дүн</b>		<b>920,165</b>			<b>828,148,500.0</b>

Үйл ажиллагааны зардлын дүн = 828,148,500.0 (0.8 тэрбум) төгрөг

#### **2.4. Зардлыг нэгтгэн тооцох:**

Хуулийн төсөл батлагдсанаар төр буюу улсын төсөвт шинээр дараах зардал үүсэхээр байна:

#### **Төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх нийт зардал**

Нийт зардлыг өссөн дүнгээр тооцсон хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэр дүнгээр тооцон гаргана:

(Тэрбум төгрөгөөр)

№	Зардлын нэр	Мөнгөн дүн	Тайлбар
---	-------------	---------------	---------

1.	Хүний нөөцийн зардал /Цалингийн сан, байгууллага төлөх НДШ/	14.0	Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт
2.	Материаллаг зардал /Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах/	1.6	Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар тооцсон.
3.	Үйл ажиллагааны зардал	0.8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын "Аргачлал, зардлын норматив батлах тухай" 2022 оны А/23,27 хамтарсан тушаалаар батлагдсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ыг баримтлав.
<b>Нийт зардал</b>		<b>16.4</b>	

**Төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх  
жилийн зардал**

(Тэрбум төгрөгөөр)

№	Зардлын ангилал	Орон тоо	1 хүн	Жилд /төгрөг/	Тайлбар
1	Үндсэн цалин	204	1,470,700	3,600,273,600.0	ТҮБД-4 тооцов. Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт
		330	1,470,700	5,823,972,000.0	ТҮБД-4 тооцов. Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт
2	Нэмэгдэл	204	514,745	540,041,040.0	
		330	514,745	873,595,800.0	
3	Хоол, унаа	204	15,000	740,520,000.0	
		330	10,000	798,600,000.0	
<b>Цалингийн сан</b>				<b>12,377,002,440.0</b>	
4	<b>НДШ /12.5%/</b>			<b>1,670,895,329.4</b>	
5	<b>Тоног төхөөрөмж, тавилга эд хогшил</b>	<b>534</b>	<b>2,956,270</b>	<b>1,578,648,180.0</b>	
6	<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>534</b>		<b>828,148,500.0</b>	
<b>Нийт дүн</b>				<b>16,454,694,449.4</b>	



Төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх  
нийт зардлын дүн = **16,454,694,449.4 төгрөг**

Хуулийн төслийг батлан хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх нийт зардал 16,454,694,449.4 (16.4 тэрбум) төгрөгийн тооцоо гарч байна.

#### **ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар төрийн байгууллагад үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг удирдлага болгон зардлын тооцоог гаргалаа.

Аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээдийн зардал үүсгэхээр шинээр зохицуулалт тусгагдаагүй байна.

Харин Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн хийсэн зардлын тооцооны үр дүнг нэгтгэн үзэхэд урьдчилсан байдлаар нэмэлтээр 16,454,694,449. (арван зургаан тэрбум дөрвөн зуун тавин дөрвөн сая зургаан зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун дөчин ес) төгрөгийн зардал төрийн байгууллагад шинээр үүсэхээр байна. Энэхүү зардал нь Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал тул хялбаршуулах, үүргийг нэгтгэн бууруулах боломжгүй гэж дүгнэв.

---oOo---